

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/021/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichnkhorooga@audit.gov.mn](mailto:ichnkhorooga@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 01/310  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА  
Д.БОЛД-ЭРДЭНЭ ТАНАА**

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 136.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь бүрэн биелүүлээгүй 16.2 сая төгрөг болон Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй холбоотой 35.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Чандмань-Өндөр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулж 90.4 хувьтай биелүүлж ажилласан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		807,330.67	673,088.51
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	627,215.36	429,986.65
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	22,883.84	35,043.49
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	157,231.47	208,058.37
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,070,912.65	1,192,447.13
6	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	107,290.23	74,604.3
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	963,622.42	1,117,842.83
8	Биет хөрөнгө		878,227.59	983,092.72
9	Биет бус хөрөнгө	13	85,394.83	134,750.1
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		1,878,243.32	1,865,535.63
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.0	89,414.51
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	89,414.51
13	Өглөг		0.0	89,414.51
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,878,243.32	1,776,121.12
15	Засгийн газрын хувь оролцоо		1,878,243.32	1,776,121.12
16	Засгийн газрын оруулсан капитал		330,172.4	330,172.4
17	Хуримтлагдсан үр дүн		1,239,438.95	1,140,340.07
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		308,631.97	305,608.65
19	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		1,878,243.32	1,865,535.63

**Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		1,961,083.82	1,767,005.3
2	ТАТВАРЫН ОРЛОГО		800,532.82	899,573.85
3	Орлогын албан татвар		461,708.61	495,998.81
4	Хувь хүний орлогын албан татвар		461,708.61	495,998.81
5	Хөрөнгийн албан татвар		32,691.57	36,464.34
6	Бусад татвар, төлбөр, хураамж		306,132.64	367,110.7
7	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	32,231.75	867,431.45
8	Хөрөнгийн орлого		0.0	2,580
9	Тусламжийн орлого		0.0	565,392.74

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан**

10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,128,319.24	0.0
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,560,610.92	1,864,357.58
12	УРСГАЛ ЗАРДАЛ		1,560,610.92	1,864,357.58
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,463,518.8	1,847,465.58
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		711,145.91	853,184.36
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		88,460.17	101,016.09
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		235,750.36	267,949.7
17	Хангамж, бараа материалын зардал		70,118.86	107,218.35
18	Эд хогшил, урсгал засварын зардал		147,580.15	252,118.48
19	Томилолт, зочны зардал		6,465.60	7,547.20
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		31,001.60	45,048.64
21	Бараа үйлчилгээний бусад зардал		172,996.15	213,382.76
22	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		97,092.12	16,892
23	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		400,472.9	-97,352.29
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		38,560.90	4,769.91
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-38,560.90	-4,769.91
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		361,912.00	-102,122.20

**Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

№	Дансны нэр, төрөл	/мянган төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,005,509.07	1,698,710.59
2	ТАТВАРЫН ОРЛОГО	800,532.82	899,573.85
3	Орлогын албан татвар	461,708.61	495,998.81
4	Хөрөнгийн албан татвар	32,691.57	36,464.34
5	Бусад татвар, төлбөр, хураамж	306,132.64	367,110.7
6	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,506.73	14,160.06
7	Газрын төлбөр	14,423.04	26,440.59
8	Байгалийн нөөц ашигласны төлбөр	281,202.87	326,510.05
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,657	799,136.74
10	Нийтлэг татварын бус орлого	76,657	46,360.61
11	Хөрөнгийн орлого	0.0	2,580
12	Тусламжийн орлого	0.0	565,392.74
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	184,803.4

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,128,319.24	0.0
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,292,620.61	1,434,520.72
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,292,620.61	1,434,520.72
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,198,628.49	1,417,346.72
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	711,157.88	853,166.57
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,396.99	101,033.88
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,767.86	266,302.35
21	Хангамж, бараа материалын зардал	38,151.36	41,672.98
22	Нормативт зардал	1,500	0.0
23	Эд хогшил, урсгал засварын зардал	44,464.3	35,109
24	Томилолт, зочны зардал	6,465.6	6,819.6
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,301.6	46,729.14
26	Бараа үйлчилгээний бусад зардал	36,422.9	66,513.2
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,992.12	17,174
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	712,888.45	264,189.87
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	267,856	461,418.58
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	267,856	461,418.58
31	Дотоод эх үүсвэрээр	267,856	461,418.58
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-267,856	-461,418.58
33	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	445,032.45	-197,228.71
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	182,182.9	627,215.36
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	627,215.36	429,986.65

**Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,516,797.22		1,516,797.22
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-465.9		-465.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,516,331.32		1,516,331.32
4	Тайлант үеийн үр дүн	361,912		361,912
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,878,243.32		1,878,243.32
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,878,243.32		1,878,243.32
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,023.32		3,023.32
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,881,266.64		1,881,266.64

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан**

9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,023.32		-3,023.32
10	Тайлант үеийн үр дүн	-102,122.2		-102,122.2
11	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,776,121.12		1,776,121.12

**Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,172,107.0	1,865,890.7	306,216.3	85.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	190,394.6	184,803.4	5,591.2	97.1
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	190,394.6	184,803.4	5,591.2	97.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,336,316.3	1,654,352.7	(318,036.4)	123.8
320001	Орон нутгийн төсвөөс	1,336,316.3	1,654,352.7	(318,036.4)	123.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	645,396.1	26,734.6	618,661.5	4.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,000.0	24,380.3	17,619.7	58.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,200.0	2,354.3	(1,154.3)	196.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	602,196.1		602,196.1	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,172,107.0	1,881,199.8	290,907.2	86.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,574,297.7	1,482,140.6	92,157.1	94.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,563,297.7	1,471,140.6	92,157.1	94.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	901,760.8	853,166.6	48,594.2	94.6
210101	Үндсэн цалин	715,639.0	498,308.0	217,331.0	69.6
210102	Нэмэгдэл	141,874.0	314,240.3	(172,366.3)	221.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,000.0	1,575.0	2,425.0	39.4
210104	Урамшуулал	40,247.8	39,043.3	1,204.5	97.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,423.1	101,033.9	11,389.2	89.9
210201	Тэтгэврийн даатгал	76,352.5	71,736.7	4,615.8	94.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,017.7	8,401.4	616.3	93.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,508.8	4,572.1	(63.3)	101.4
210204	Ажилгүйдлийн даатгал	4,508.8	3,377.2	1,131.6	74.9
210205	Эрүүл мэндийн даатгал	18,035.3	12,946.5	5,088.8	71.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269,423.1	266,302.4	3,120.7	98.8
210301	Гэрэл, цахилгаан	68,660.5	74,354.9	(5,694.4)	108.3
210302	Түлш, халаалт	190,762.6	191,947.5	(1,184.9)	100.6
210303	Цэвэр, бохир ус	10,000.0	-	10,000.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	46,721.0	39,773.3	6,947.7	85.1
210401	Бичиг хэрэг	3,200.0	2,277.0	923.0	71.2
210402	Тээвэр, шатахуун	26,191.0	24,248.6	1,942.4	92.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,480.0	3,343.5	136.5	96.1
210404	Ном, хэвлэл	250.0	192.0	58.0	76.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,000.0	8,905.1	3,095.0	74.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600.0	807.2	792.8	50.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,061.5	49,300.2	7,761.3	86.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,400.0	12,553.0	1,847.0	87.2
210604	Урсгал засвар	42,661.5	36,747.2	5,914.3	86.1
2107	Томилолт, зочны зардал	9,000.0	6,819.6	2,180.4	75.8

**Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан**

210702	Дотоод албан томилолт	9,000.0	6,819.6	2,180.4	75.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,235.7	93,231.5	8,004.2	92.1
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	96,980.7	89,337.6	7,643.1	92.1
210803	Даатгалын үйлчилгээ	500.0	391.2	108.8	78.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200.0	62.7	137.3	31.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55.0	55.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500.0	1,385.0	115.0	92.3
210807	Газрын төлбөр	2,000.0	2,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,672.5	61,513.2	4,159.3	93.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,172.5	57,555.7	3,616.8	94.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500.0	3,957.5	542.5	87.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,000.0	11,000.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,000.0	11,000.0	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,000.0	11,000.0	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	486,049.3	398,980.2	87,069.1	82.1
223001	Бусад хөрөнгө	486,049.3	398,980.2	87,069.1	82.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	111,760.0	-	111,760.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	111,760.0	-	111,760.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	190,821.3	(190,821.3)	#DIV/0!
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	175,512.2	(175,512.2)	#DIV/0!

**Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	14,739.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,739.5
122	Тусламжийн орлого	14,739.5
1221	Хандив тусламж /дотоод/	14,739.5
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,739.5
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,759.5
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	980.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,739.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,739.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,644.5
2104	Хангамж, бараа материалын зардал	1,899.6
210402	Тээвэр, шатахуун	1,749.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,744.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,744.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,095.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,095.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,095.0

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг түүвэрт хамруулан аудит хийсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилтэй асуудал илрээгүй байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 51.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдэлт болон хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн 51.0 сая төгрөгийн зөрчлийг материаллаг зөрчилд тооцоогүй тул өөрчлөлтгүй дүгнэлт гаргасан болно.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл хөрөнгө борлуулсны орлого 1.0 сая төгрөг, шууд бус орлого 1.6 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 2.7 сая төгрөг, бууны албан татвар 0.2 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 1.1 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.1 сая төгрөг, газрын төлбөр 4.3 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 2.1 сая төгрөг нийт 16.2 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

#### 2. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд 6 иргэнтэй холбоотой 35.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулж ажиллах.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг бүрэн барагдуулаагүй	1	35.0					1	35.0
Орлогыг нэр төрлөөр нь тасалсан	1	16.2					1	16.2
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>51.2</b>					<b>2</b>	<b>51.2</b>